

**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

№	2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцан хэрэгжүүлэх албан хаагч	Төсөвт өртөг	Биелэлт	Хувь
НЭГ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС					
1	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудаас үйл ажиллагааны тайланг 14 хоног, сар, хагас, бүтэн жилээр хүлээн авч нэгтгэн баталгаажуулж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэх	Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн		Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс тасгийн үйл ажиллагааны тайланг сар, хагас жилээр хэлтэс, тасгуудаас хүлээн авч Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны 335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтанд танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлант хугацаанд нь цахимаар болон албан бичгээр хүргүүлэн ажилласан.	100
2	Тамгын газрын даргын үр дүнгийн гэрээ, гэрээний биелэлтийг гаргаж дүгнүүлэх	Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн		Төсвийн Шууд захирагч Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах 2018 оны Үр дүнгийн гэрээний төслийг Төрийн албаны зөвлөлийн 134 дүгээр тогтоолын дагуу боловсруулан батлуулж, үндсэн үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнд нийт 104, тусгай ажил үйлчилгээ түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 48, дотоод ажил үйлчилгээ түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээнд 9 ажил үйлчилгээг тусган жилийн эцсийн байдлаар 96 хувь буюу А үнэлгээтэй, хоёрдугаар хавсралт болох календарчилсан төлөвлөгөөнд нийт 279 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 96 хувийн гүйцэтгэлтэй тус тус биелэгдсэн.	100
3	Тамгын газрын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах, өмнөх зөвлөгөөн дээр гарсан санал, шүүмжлэлийн биелэлтийг гаргаж мэдээлэх, зөвлөгөөний тэмдэглэлийг хөтлөх, санал, хүсэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн		Тамгын газрын албан хаагчдын нэгдсэн зөвлөгөөнийг 2018 оны 04 дүгээр сарын 09, 12 дугаар сарын 26-ны өдөр тус тус зохион байгуулсан. Тус зөвлөгөөнийг Тамгын газрын дарга Б.Энхболд нээж, Тамгын газрын хэлтэс, тасгууд 2018 оны үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа. Тус зөвлөгөөнийг хааж ТГ-ын дарга 2018 онд хийгдсэн ажлуудын алдаа, дутагдал, ололт амжилтын талаар санал бодлоо хэлж, үнэлэлт дүгнэлт өгсөн бөгөөд 2019 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа томоохон ажлын талаар мэдээлэл хийж 2018 оны ажил үйлсээрээ манлайлсан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулсан. Зөвлөгөөнд хэлтэс, тасгийн 71 албан хаагчид оролцсон.	90
4	Засаг даргын Тамгын газрын	Захиргааны зохион		Тамгын газрын 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны календарчилсан	100

	хэлтэс, тасгаас Тамгын газрын төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг авч, нэгтгэн батлуулж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргах	байгуулалт хариуцсан мэргэжилтэн		төлөвлөгөөнд тусгах ажлын саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч, нэгтгэн боловсруулж, батлуулсан. Төлөвлөгөөнд 279 ажил хийхээр тусган, хагас жилийн байдлаар бүрэн хэрэгжсэн-55, хэрэгжих шатандаа явж байгаа-180, хэрэгжээгүй-1, хойшлогдсон-9, хугацаа болоогүй -34 ажил байна. Нийт ажил 57%-тай, жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн- 274, хэрэгжээгүй 1, хойшлогдсон-38 хугацаа болоогүй-1 ажил 96 хувьтай тус тус хэрэгжсэн байна.	
5	Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, Тамгын газрын дотоод ажлыг уялдуулан зохицуулах, зохион байгуулах, ажлын үр дүнг тооцох, мэдээлэх	Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн		Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг 2018 онд нийт 38 удаа зохион байгуулж, 318 үүрэг даалгавар өгөгдөж, 96 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.	100
6	“Явуулын нэг цэгийн үйлчилгээ”-ээр төрийн үйлчилгээг 16 хороодын иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах	Захиргааны зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн		Удирдлагын шийдвэрээр 2019 онд зохион байгуулахаар хойшлогдсон.	-
7	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, “Авилгын эсрэг нийслэлийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө батлах тухай” 23/01 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Авлигын эсрэг төлөвлөгөөг боловсруулж дүүргийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/18 дугаар захирамжаар 2018 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан нийт 20 заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2018 оны хагас жилийн байдлаар 60 хувьтай, жилийн эцсийн байдлаар 90 хувьтай тус тус хэрэгжсэн. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй нийтийн албаны ашиг сонирхлын сургалтад Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадын 100 гаруй албан хаагчдыг тус тус хамруулсан. 2018 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 26 албан хаагчаас хүлээн авч тайланг нь хүргүүлсэн. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг нэгтгэн товхимол хэвлүүлсэн.	100
8	Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн		2018 оны жилийн эцсийн байдлаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон харьяа нэгж байгууллагын нийт албан тушаалтнуудаас 27 албан тушаалтны Хөрөнгө орлогын мэдүүлгийг цаасаар болон цахимаар авч бүртгэн баталгаажуулсан байна.	100

9	“Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх”, “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-үүдийн хүрээнд Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудаас 2018 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд тусгах саналыг авч нэгтгэн батлуулж, хэрэгжилийн хангуулан ажиллах	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн		Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах” хөтөлбөрийн хүрээнд Тамгын газрын албан хаагчдын орон байрны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд 2018 оны ажлын үр дүнг болон өргөдөл, хүсэлтийг харгалзан, Нийгмийн баталгааг хангах ажлын хэсэг 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдөр хуралдан 21 албан хаагчдад 200.000 сая төгрөг, буцалтгүй тусламж олгосон.	100
10	Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн албан хаагчдын сургалтын хэрэгцээ шаардлагыг судлан санал, харьяа дээд байгууллагаас өгсөн зөвлөмжүүдийг үндэслэн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн		Засаг даргын Тамгын газрын 2018 оны сурган хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд нийт 14 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ЗДТГ-ын даргаар батлуулсан. Дээрх төлөвлөгөөний хүрээнд дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд: Удирдлагын академийн мэргэшүүлэх богино болон дунд хугацааны сургалтад 23, Мэргэшсэн нягтлан бодогчдын мэргэшүүлэх сургалтад 5, гадаадын улс орнуудад 19 албан хаагчийг тус тус хамруулаад байна. Авлигын эсрэг сургалт, Төрийн албаны тухай хуулийн шинэчлэсэн найруулгын талаарх танилцуулах сургалт, Зөрчлийн тухай хуулийн сургалт, Судалгааны арга зүй, excel програмын сургалт, Байгууллагын соёл сургалт, Баримт бичиг боловсруулах арга зүйн сургалт, Албан хэрэг хөтлөлтийн сургалт, "Анхан шатны тусламж" эрүүл мэндийн сургалт, Гэр бүлийн боловсролын тухай сургалт, Эрүүл хооллох тухай сургалт зэрэг нийт 30 гаруй сургалтад давхардсан тоогоор 430 гаруй албан хаагчид хамрагдсан.	100
11	Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллах	Хүний нөөц, ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн		ЗДТГ-ын Ёс зүйн хорооны 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Захиргааны ажилтны ажлын байранд дагаж мөрдөх “Харилцаа, хандлагын нийтлэг журам”, “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам”-ын дагуу зөрчил гаргасан албан хаагчдад арга хэмжээ авсан. Иргэдээс ирсэн нийт 46 санал гомдлыг тухай бүр шийдвэрлэн хариу өгсөн. Мөн Сахилга хариуцлага дэг журмыг чангатгах Засгийн газрын 258 дугаар тогтоолын хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан дүүргийн Засаг даргаар батлуулж хэрэгжилтийг хангуулан биелэлтийг улирал тутам гарган холбогдох дээд шатны байгуулагад хүргүүлэ ажилласан.	100
12	Засаг даргын зөвлөлийн хурлыг журмын дагуу зохион байгуулж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг	Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал хариуцсан мэргэжилтэн		2018 оны жилийн эцсийн байдлаар Засаг даргын Зөвлөл 16 удаа хуралдаж дүүргийн “Ахмадаа дээдлэе”, “Зөв хүүхэд-зөв ирээдүй”, “Аз жаргалтай гэр бүл” “Хорооны хөгжил-Төрийн үйлчилгээ” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ зохион байгуулах, иргэдийн санал бодолд	100

	хангуулан мэдээлж, зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг тайлагнаж, биелэлтийг тооцох.			тулгуурлан шийдвэрлэх асуудал, цаг үеийн тулгамдсан ажлууд зэрэг 93 асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргаж, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргуулсан.	
13	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс Монгол Улсын Төрийн дээд одон медалиар шагнуулахаар нэр дэвшигдэж ирсэн иргэдийн материалын бүрдэлтийг хянан шалгаж холбогдох дээд шатны байгууллагад уламжлан хүргүүлэх	Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал хариуцсан мэргэжилтэн		Төрийн дээд одон медалиар шагнуулах хүсэлтээ ирүүлсэн 224 иргэний материалыг хүлээн авч дүүргийн ИТХТ-ий хурлаар дэмжүүлэн батлуулж, НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 3 удаагийн зарлигаар Төрийн дээд одон Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 4 иргэнийг, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 43 иргэнийг, Алтан гадас одонгоор 149 иргэнийг Хөдөлмөрийн хүндэт медалиар 59 иргэнийг, Цэргийн хүндэт медалиар 1, Шударга журам медалиар 1, нийт 262 иргэн шагнагдан, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан.	100
14	Засгийн газар, яамны шагналаар шагнуулахаар тодорхойлогдож ирсэн иргэдийн материалыг шагналын журмын дагуу бүрдэлтийг шалган авч холбогдох яам руу уламжлан хүргүүлэх	Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал хариуцсан мэргэжилтэн		Засаг даргын албан бичгээр Эрүүл мэндийн яаманд 10, Зам, тээвэр хөгжлийн яаманд 15, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 16, Боловсрол соёл шинжлэх ухааны яаманд 15, Сангийн яаманд 8, нийт 64 иргэний материалыг дэмжин уламжилж хүргүүлсэн.	100
15	Нийслэл, дүүргийн Засаг даргын шагналаар шагнуулахаар тодорхойлогдон ирсэн иргэдийн материалын бүрдлийг шалган авч шагналын ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх, шагнал гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн Засаг даргын шагнал “Хүндэт тэмдэг”-ээр 60, “Жуух бичиг”-ээр 150, “Өргөмжлөл”-өөр 149, “Хан-Уул авьяастан медаль”-аар 15, “Шилдэг сурагч өргөмжлөл”-өөр 16, нийт 390 иргэн шагнагдсан байна. Нийслэлийн “Тэргүүний ажилтан” цол тэмдгээр 10 албан хаагчийг, “Жуух бичиг”-ээр 8 албан хаагч тус тус шагнагдсан.	100
16	Алдарт эхийн I, II дугаар зэргийн одонгоор шагнуулах хүсэлт гаргасан эхчүүдийн материалыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хороодоос хүлээн авч нэгтгэн дээд шатны байгууллагад уламжлан хүргүүлэх, одон гардуулах үйл ажиллагааг зохион байгуулах	Засаг даргын зөвлөлийн хурал, шагнал хариуцсан мэргэжилтэн		2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн А/18 дугаар тогтоолоор “Алдарт эх”-ийн 1,2 дугаар зэргийн одонгоор шагнагдах 430 эхчүүдийн материалыг дэмжүүлэн нийслэлийн НЗДТГ-т хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05-р сарын 23-ны 73 дугаар зарлигаар дүүргийн хэмжээнд 21 эх “Алдар эх” 1 дүгээр зэргийн одонгоор, 323 эх “Алдар эх” 2 дугаар зэргийн одонгоор тус тус шагнагдлаа. Одон гардуулах ёслолын арга хэмжээ 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Хүүхдийн ордонд дүүргийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчидтэй хамтран 500 ээжид зориулсан “Ээж бол ертөнц” баярын арга хэмжээг зохион байгуулсан.	100

				Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Цэрэн, Дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан болон УИХ-ын гишүүд, Нийслэл дүүргийн төлөөлөгчид одон гардуулах ёслолын ажиллагаанд оролцож ээжүүдэд одонг нь гардуулан өгөх арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.	
17	Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг хүргүүлж ажиллана.	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн		2018 оны эхний хагас жилийн байдлаар 8 төрлийн 61 захирамжлалын баримт бичгийн холбогдох 116 заалтын хэрэгжилт 72.4 хувьтай хэрэгжсэн. 2018 оны жилийн эцсийн байдлаар биелэлтийг тооцож мэдээлэх 12 төрлийн 105 захирамжлалын баримт бичгийн холбогдох 208 заалтыг http://monitoring.ub.gov.mn/ програм, http://www.legalinfo.mn/ , http://ulaanbaatar.mn/ мэдээллийн эх үүсвэрээс түүвэрлэн авч, Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудад жагсаалтаар, Засаг даргын дэргэдэх 26 хэлтэс, албадад Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн биелэлт ирүүлэх тухай 01/2261 тоот албан бичгээр тус тус хүргүүллээ. Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан 22 мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгсөн. Тогтоол шийдвэрийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн 2018 оны 12 сарын 20-ны дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнана.	100
18	Дээд газрын захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулж, хэрэгжилт, үр дүнг тогтоосон хугацаанд мэдээлэх	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн		2018 оны 1 дүгээр улиралд биелэлт гаргах Нийслэлийн Засаг даргын 22 захирамж хүлээн авч холбогдох 57 заалтын биелэлтийг тооцон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст мэдээллэлээ. /Биелэлт 40,36 %/ 2018 оны 2 дугаар улиралд нийт 38 захирамжлалын баримт бичгийн хяналтад авсан 59 заалтын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж /Биелэлт 73,2%/-тай үнэлэгдсэн. 2018 оны 3 дугаар улиралд Нийслэлийн Засаг даргын 7 захирамжийн хяналтад авсан 9 заалтын хэрэгжилтийг тооцож, "Leader monitoring" програмд байршуулсан. /Биелэлт 68,8%/ 2018 оны 4-р улирлын байдлаар нийт 49 захирамжийн хяналтад авсан 79 заалтын хэрэгжилтийг гарган, биелэлт тооцсон захирамжлалын баримт бичгийн мэдээнд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгүүлэн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст тайлагнана.	100
19	Дүүргийн төр, захиргааны байгууллагын Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг, журмын дагуу зохион байгуулж, Нийслэл, дүүргийн шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 12 удаа зохион байгуулж, Засаг даргаас өгсөн нийт 131 үүрэг даалгавар 87,5 хувьтай биелэгдсэн. Шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавар болон биелэлтийг http://www.khanuul.mn/ сайтад тухай бүр байршуулж байна. Нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 23 удаа зохион байгуулагдан, нийт 177 үүрэг даалгавар	100

	биелэлтийг хангуулж хугацаанд нь мэдээлэх			өгөгдөж, 88,9 хувьтай биелсэн байна. Биелэлтийг 14 хоног тутам пүрэв гарагт хугацаанд нь https://backend.ulaanbaatar.mn/ програмд мэдээлж ажилласан.	
20	Дүүргийн Засаг даргын “Нийслэлийн төр, захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн”-д 14 хоног тутам танилцуулах мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас авч боловсруулалт хийж бэлтгэх	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн шуурхай зөвлөгөөнд мэдээлэх 2017 онд дүүргийн тохижилт, хөрөнгө оруулалтын чиглэлээр хэрэгжүүлсэн онцлох ажлын танилцуулгыг бэлтгэн хүргүүлснээр дүүргүүдийн 2017 онд хэрэгжүүлсэн онцлох ажлын мэдээлэл Хан-Уул дүүргээс эхэлсэн.	100
21	Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг журмын дагуу зохион байгуулж, иргэдээс тавьсан санал хүсэлтийн шийдвэрлэлтэд хяналт тавьж тайлагнана.	Тогтоол, шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн		2018 оны жилийн эцсийн байдлаар 2 удаагийн хуваарьт уулзалтаар нийт 20 иргэнийг хүлээн авч, хүсэлтийг нь сонсож хариулт өгсөн. б/ Засаг даргад хандаж хүсэлт гаргасан иргэдээс Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, түрээсийн орон сууцанд хамрагдах болон газрын асуудлаар ихэвчлэн хандаж байна. Түрээсийн орон сууц, хог хаягдал цэвэрлэгээ, нохой устгалтай холбогдолтой 10 асуудлын хариуг газар дээр нь өгч, шийдвэрлэн, газрын асуудлаар хандсан 10 иргэний хүсэлтийг Газрын албанд шилжүүлэн судлуулж байна. Уулзалтын хуваарь, журам, мэдээ, уулзалтын үед иргэдээс тавьсан санал хүсэлтийн шийдвэрлэлтийг www.khanuul.mn цахим хуудсанд тухай бүр мэдээлж “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.	100
22	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах	Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн		Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, ЗДТГ-ын даргаар 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100
23	Засаг дарга болон ЗДТГ-ын удирдлагуудыг гадаад харилцааны чиглэлээр мэдээлэлээр хангах, гадаад томилолт, гадны зочид төлөөлөгчдийг урих, хүлээж авах үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах	Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн		2018 оны жилийн эцсийн байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон Улс, Бүгд Найрамдах Болгар Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Австрали болон Америкийн Нэгдсэн Улсын нийт 9 удаагийн гадаад албан томилолтыг зохион байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн тайлан мэдээг тухай бүрд нь гарган дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын Өмнөд Гёнсан аймгийн Хаман сум, Бусан хотын Хэүндэ дүүргийн дэргэдэх “Сайн дурын үйлчилгээ үзүүлэх төв”, Гёнсан Их Сургууль болон Япон Улсын Мусашимураяама хотын нийт 41 зочид төлөөлөгчийг хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулав. Бүгд Найрамдах Солонгос Улсын Жинжү хотын Гёнсан Их Сургуулийн удирдлагуудыг хүлээн авч тус сургуулийн танилцуулах өдөрлөгийг зохион	100

				байгуулах ажлыг гүйцэтгэсэн.	
24	Гадаад хэргийн яам, хилийн чанадад суугаа консулын газрууд, манай улсад суугаа элчин сайдын яамдуудтай шаардлагатай үед холбоо тогтоон харилцан хамтарч ажиллах, тайлагнах	Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн		Гадаад харилцааны асуудлаар Гадаад харилцааны яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монгол Улсаас БНСУ-ын Бусан хотод суугаа Консулын газар, Монгол Улсаас БНБУ-д суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам, Монгол Улсаас Канад Улсад суугаа Элчин сайдын яам, Австрали Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яам, БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтарч ажиллав. Бичиг баримтын бүрдүүлэлтийг хийж цаг тухайд нь яаралтай хүргүүлж ажилласан.	100
25	Тамгын газрын ажилтан, албан хаагчдын гадаадын богино, дунд хугацааны сургалтад явах бэлтгэл ажлыг хангуулах	Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн		Бүгд Найрамдах Солонгос Улсын Өмнөд Гёнгсан аймгийн Хаман сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагч, мэргэжилтнүүд Хан-Уул дүүрэгт айлчлан хөдөө аж ахуйн чиглэлээр хийсэн сургалтын ажлыг зохион байгууллаа. Австрали Улсын Сидней хотод зохион байгуулагдсан Мэргэшсэн нягтлан бодогчдын Олон Улсын бага хурал, сургалт семинарт оролцсон албан хаагчдын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллав.	100
26	Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн байдал үр дүнд хяналт тавьж, эрчимжүүлэх арга хэмжээ авснаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг нийслэлийн түвшинд хүргэж ажиллана.	Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандсан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмыг мөрдөж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр зорин ажиллаж байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2018 байдлаар иргэдээс нийт 785 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэн. Үүнээс хугацаанд нь шийдвэрлэсэн 776, шийдвэрлэх шатандаа 8 өргөдөл, гомдол байна.	100
27	Нэг цонхны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллах.	Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		“Нэг цэгийн үйлчилгээ”-ний өдөр тутмын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангуулан, 2018 оны байдлаар давхардсан тоогоор 121045 иргэн үйлчлүүлсэн байна. Тус төвөөр өдөрт 200-300 иргэн тогтмол үйлчилгээ авдаг бөгөөд Төрийн үйлчилгээний мэдээлэл лавлагаа, Өргөдөл гомдол хүлээн авах төв, Эд хөрөнгийн бүртгэл, Гадаад паспорт хүлээн авах, Улаанбаатар хотын банк, Нотариат, Кадастр, Зурагчин, канон зэрэг 11 цонхоор 45 төрлийн үйлчилгээ хүргэдэг. Үүнээс гадна иргэдэд зориулан лавлагаа авдаг “ТҮЦ” машин, “Ухаалаг мэдээллийн самбар” байрлуулснаар шаардлагатай бичиг баримтаа энэхүү ухаалаг самбараасаа шууд удирдан хэвлэн авах боломжтой болсон.	100
28	Нэг цонхны үйлчилгээний төвөөр үйлчлүүлж байгаа	Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт,		Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл	100

	иргэдээс сар бүр сэтгэл ханамжийн судалгаа авах.	нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.6, 9.7, 9.8-д заасан хөндлөнгийн байгууллагаар хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар тогтоолоор баталсан "Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж"-ийн дагуу "Тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ-тай хамтран ажиллахаар 2018 оны 10 дугаар сарын 22-нд судалгааны ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, холбогдох шаардлагатай өмнөх оны мэдээ, судалгаа, тайланг гаргаж өгч ажилласан. Судалгааны ажил дууссан, тайлан мэдээг нэгтгэж удирдлагад танилцуулахад бэлдэж байна.	
29	Ухаалаг мэдээллийн самбарын мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж баяжуулах, үйлчилгээний талаар лавлагааны сантай болох.	Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, нэг цэгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн		Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас ухаалаг мэдээллийн самбарын мэдээллийг шинэчлэх болсонтой холбогдуулан ЗДТГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/861, 11 сарын 28-ны өдрийн 01/2305 тоот албан бичгээр саналыг хүлээн авч мэдээллийг байршуулсан. Ухаалаг мэдээллийн дэлгэцээр ЗДТГ-ын хэлтэс, тасаг, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Албан бус насан туршийн боловсролын төв, Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Биеийн тамир спортын хороо, Бүртгэлийн хэлтэс, Соёлын ордон, Газрын алба, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, Статистикийн хэлтсийн мэдээллүүд бүрэн байршиж, 4000 гаруй иргэн үйлчилгээ авсан байна.	100
30	Хороодын Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг зохион байгуулах, шуурхайгаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан мэдээлэх	Хороо хариуцсан мэргэжилтэн		Хорооны Засаг дарга нарын шуурхай зөвлөгөөнийг 9 удаа зохион байгуулж, шаардлагатай мэдээ мэдээллээр хангаж нийт 52 үүрэг даалгавар өгөгдсөн нь 93,2%-тай хэрэгжсэн.	94
31	Хороодын дунд "Шилдэг хороо", "Хэсгийн ахлагч нарын шилдэг баг" шалгаруулах тэмцээн зохион байгуулж үр дүнг дүгнэх	Хороо хариуцсан мэргэжилтэн		Шилдэг хороо", "Шилдэг хэсгийн ахлагч нарын баг" шалгаруулах болзолт уралдааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулах тухай Засаг даргын Тамгын газрын даргын А/76 дугаар тушаалыг гарган батлуулж хэлтэс, тасаг, хороодод хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд хороодоос ажлын төлөвлөгөө гаргуулан авч ажилласан. Шилдэг хороо", "Шилдэг хэсгийн ахлагч нарын баг" шалгаруулах болзолт уралдааны хүрээнд хороодын зохион байгуулагч нартай уулзалт зөвлөгөөнийг 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хэсгийн ахлагч нарыг чадавжуулах сургалт, уулзалтуудыг тус тус зохион байгуулж, 1,2,6,11 дүгээр хороод	100

				шилдэгээр шалгарсан.	
32	Хороодын албан хаагчдын дунд "Ажил мэргэжил, ур чадварын" тэмцээн зохион байгуулж үр дүнг дүгнэх	Хороо хариуцсан мэргэжилтэн		Хороодын албан хаагчдын дунд "Ажил мэргэжил, ур чадварын" тэмцээнийг удирдлагуудын шийдвэрээр хойшлуулж, 2018 оны 10 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд 16 хорооны 90 хэсгийн ахлагчийг Сэлэнгэ аймгийн ЗДТГ болон ОХУ-ын Улаан-Удэ хоттой туршлага судлах аялалыг зохион байгуулсан.	100
33	Хороодын албан хаагчдыг вакум сургалтад хамруулах	Хороо хариуцсан мэргэжилтэн		Хороодын Засаг дарга, Зохион байгуулагч, Хөгжлийн нийгмийн ажилтан, Хэсгийн ахлагч нарыг 2018 оны 09 дүгээр сарын 18,19-нд чадваржуулах чиглэлээр сургалтад хамруулсан.	100
34	Хороодын хэсгийн ахлагч нарыг чадавхижуулах сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	Хороо хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарын уулзалт зөвлөгөөнийг 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд ЗДТГ-ын дарга Б.Энхболд, Засаг даргын зөвлөх Ч.Бат-Оргил, 16 хороодын Засаг дарга нар оролцож, Хан-Голомт ТББ-ын захирал Ц.Азбаяр төрийн албан хаагчын харилцаа хандлага, ёс зүй, байгууллагын соёлыг хөгжүүлэх сэдэвт сургалтууд зохион байгуулсан.	100
35	Иргэдэд үйлчлэх төв байрны хяналтын камерын нэгдсэн системийг шинэчлэх	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн		Иргэдэд үйлчлэх төв байрны хяналтын камерын нэгдсэн системийг бүрэн шинэчлэн ашиглалтад оруулсан.	100
36	Мэдээлэл хуулбарлах нөөцлөх, мэдээллийн санг архивлах, дата сервер ашиглалтад оруулах	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн		Мэдээллийг хуулбарлан нөөцлөх, мэдээллийн санг архивлах, төхөөрөмжийн техникийн даалгавар бүрэн хийгдсэн.	100
37	Хүний нөөцийн програм хангамжийг нэвтрүүлэх	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн		Хүний нөөцийн цогц програм хангамжийн техникийн даалгавар бүрэн хийгдэж, албан хаагчийн хувийн хэрэг хөтлөлтийг бүрэн шивж оруулсан бөгөөд, бусад мэдээллийн баяжуулалтыг хийж байна.	95
38	Өмч тооллогын програм хангамж нэвтрүүлнэ	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн		2018 оны 10 дугаар сарын 18 -ны өдөр "Зэнд" ХХК-тай А/54 дугаартай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан Өмч тооллогын цогц програм хангамжийг хийж ашиглалтад хүлээн авсан.	100
39	Засаг даргын Тамгын газар болон хороодын компьютер, техник хэрэгсэл, дотоод сүлжээ, серверийн байнгын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах. Эвдрэл гэмтлийг цаг алдалгүй хурдан шуурхай засварлах	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн Дотоод сүлжээний инженер		Засаг даргын Тамгын газар, 16 хороодод компьютер болон дагалдах техник хэрэгслийн засварын чиглэлээр нийт 58 ажил хийгдэж, Вэб сервер, Санхүүгийн сервер, Цаг бүртгэлийн сервер, Kaspersky серверүүдийн байнгын, найдвартай хэвийн ажиллагаанд өдөр бүр хяналт тавин ажиллаж байна. Мөн Тамгын газар болон 16 хорооны албан хаагчдын компьютерыг вирусээс хамгаалах албан ёсны лиценз бүхий нэгдсэн удирдлагатай програм хангамжийг 2018 оны 05 дугаар сарын 16-ны "ОРГИЛ ДЕЛЪТА ТРЕЙД" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу нийт 160 хэрэглэгчийн эрх бүхий програмыг бүрэн суулгаж хяналт тавин ажиллаж байна.	100
40	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, алба, хороодын хэмжээнд	Мэдээлэл технологи, цахим сан хариуцсан мэргэжилтэн		Хан-Уул дүүргийн цахим хуудас болон Eoffice.mn цахим хуудсуудын ашиглалтын гэрээг "Cloud network" ХХК-тай байгуулан хяналт тавин ажиллаж байна.	100

	www.khanuul.mn, eoffice.khanuul.mn цахим хуудсуудын аюулгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллах				
41	Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон дэргэдэх хэлтэс, тасгуудын үйл ажиллагаанд Хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө боловсруулж батлуулах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/365 дугаар захирамжаар зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулсан.	100
42	Гүйцэтгэлийн хяналт, шинжилгээний дүгнэлтэд тусгасан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн		Засаг даргын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний 34 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан, 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 06 сарын 25-ны өдрийн 01/1300 тоот албан бичгээр НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар илтгэх хуудсаар авч нэгтгэхээр ЗДТГ-ын даргын 2018 оны 11 сарын 19-ний өдрийн 01/2240 тоот албан бичгийг Тамгын газрын 8 хэлтэс болон дэргэдэх хэлтэс, албадын 26 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмжийн жилийн эцсийн биелэлт, илтгэх хуудсыг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.	100
43	Дүүргийн Засаг даргын дэргэдэх болон ЗДТГ-ын үйл ажиллагаанд Гүйцэтгэлийн хяналт, шинжилгээг батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн төр захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тухай Засаг даргын А/365 дугаар захирамжийг Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 01/2302 тоот албан бичгээр дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга нарт, мөн өдрийн 01/2302 дугаар албан бичгээр хороодын Засаг дарга нарт нийт 43 байгууллагад хүргүүлж, бэлтгэл ажил хангах тухай чиглэл өгч 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн хуваарьт төлөвлөгөөний дагуу Засаг даргын дэргэдэх 17 хэлтэс, алба, 12 хороодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Батлагдсан удирдамж, төлөвлөгөөний дагуу үлдсэн байгууллагуудаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.	90
44	Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад гарсан алдаа доголдлыг илрүүлэх, холбогдох албан тушаалтанд танилцуулах, залруулах арга хэмжээ авах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн		Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан 31 үндэсний хөтөлбөрийн хагас жилийн биелэлт 85 , Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан 26 дэд хөтөлбөрийн хагас жилийн биелэлт 75 , Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас баталсан “Аз жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хүрээнд 9, “Зөв хүүхэд-Зөв ирээдүй” хөтөлбөрийн хүрээнд 14, “Ахмадаа дээдэлье” хөтөлбөрийн хүрээнд 6, “Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ” хөтөлбөрийн	90

				хүрээнд 8 төсөл арга хэмжээ буюу нийт 37 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн нийт 259.611.740 төгрөг зарцуулсан бөгөөд биелэлтийн дундаж 68.76% -ийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадаас биелэлтийг хүлээн авч нэгтгэл хийгдэж байна. Тайлангийн хугацаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдэж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	
45	Хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн		Хан-Уул дүүргийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 95,8 тэрбум төгрөгийн 29 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд он дамжин хэрэгжиж буй 6 , хэрэгжиж дууссан 1 , хэрэгжиж эхэлсэн 14 , тендер зарлагдан үнэлгээ хийгдэж буй 6 , гэрээ байгуулах шатанд 2 төсөл арга хэмжээ байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,9 тэрбум төгрөгийн 16 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжиж дууссан 10 , гэрээ байгуулагдаж ажил эхэлсэн 4 , тендер зарлагдсан 2 төсөл арга хэмжээ байна. Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 640 сая төгрөгийн 15 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд хэрэгжиж дууссан 11 , хэрэгжиж буй 3 , тендер зарласан 1 төсөл арга хэмжээ байна. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 19 төсөл арга хэмжээ, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 21 төсөл арга хэмжээний гүйцэтгэл хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	90

46	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	<p>Дүүргийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх 5 бүлэг 106 арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хагас жилийн биелэлт 50.7, 3 дугаар улирлын биелэлт 82.5, жилийн эцсийн биелэлт..... хувьтай үнэлэгдэж, илтгэх хуудсаар дүгнэлт, зөвлөмжийг удирдлагуудад танилцуулсан. Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2018 оны 5 бүлэг 108 арга хэмжээний 3 дугаар улирлын биелэлт 89.7 хувьтай үнэлэгдэж, жилийн эцсийн биелэлтэд үнэлгээ хийгдэж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 41 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 3 дугаар улирлын биелэлт 78.9, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 5 заалтын 3 дугаар улирлын биелэлт 76 хувьтай үнэлэгдэж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан болох L MONITORING програмд оруулж биелэлтийг тайлангийн хугацаанд илгээсэн.</p>	100
47	Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд шалган зааварчилсан ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд заагдсан ажлын тусгай төлөвлөгөө боловсруулж батлуулах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2018 оны 03/732 тоот албан бичгээр 2017 оны үйл ажиллагаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын хэсгээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх хариу арга хэмжээний 34 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг боловсруулан 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан.	100
48	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах, гүйцэтгэлийг тайлагнах	Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	Төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг илтгэх хуудсаар Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 01/1300 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар илтгэх хуудсаар авч нэгтгэхээр Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/2240 тоот албан бичгийг Тамгын газрын 8 болон дэргэдэх хэлтэс, албадын 26 нийт 34 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөмжийн биелэлт илтгэх хуудсыг 2018 оны 12 сарын 25-ны өдрийн дотор НЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлнэ.	90
48 ажлын биелэлт 96 хувьтай хэрэгжсэн байна				

ХОЁР. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС

49	Дүүргийн төсвийн ерөнхийлэн захирагчийн 2018 оны төсвийн төслийг боловсруулж Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Орлогын мэргэжилтэн		Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар 2018 оны орон нутгийн төсөв батлагдан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100
50	Орон нутгийн 2018-2020 оны төсвийн хүрээний дунд ба урт хугацааны төлөвлөгөөний төслийг орон нутгийн төсөвт байгууллагуудаас гаргуулан хянаж боловсруулах, нэгтгэх, Нийслэлийн төрийн санд хүргүүлж нэгтгүүлэх	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Орлогын мэргэжилтэн		Дүүргийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын тогтмол зардал болон орон нутгийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2018 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2019 оны төсвийн төсөл, 2020-2021 оны төлөвлөгөөний төслийг эцсийн байдлаар Засаг даргын 2018.08.01-ний өдрийн 02/374 тоот албан бичгээр Нийслэлийн СТСХэлтэст хүргүүлж нэгтгүүлсэн.	100
51	Төсвийн тодотгол хийх шаардлага, нөхцөл, хуулинд заасан үндэслэл үүссэн тухай бүр тодотголын саналыг боловсруулан хянуулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Орлогын мэргэжилтэн		Засгийн газраас тухайн төсвийн жилд тодотгол хийхгүй байх шийдвэр гарсантай холбоотойгоор 2018 оны 11 дүгээр сарын байдлаар төсвийн тодотгол хийгдээгүй байна.	-
52	Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд хяналт тавих, орлогын гүйцэтгэлийн мэдээг гаргах, мэдээллийг Нийслэлийн төрийн сан, дүүргийн сайтад мэдээлэх болон холбогдох хэлтэс, албадыг мэдээллээр хангах	Төсвийн орлогын мэргэжилтэн		Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд тухай бүрт нь хяналт тавин, долоо хоногт 3-5 удаа орлогын дансдын хуулгыг Татварын хэлтэст илгээн, орлогын хаалтыг тулгаж, сар бүрийн 5-ны өдрийн дотор орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, мэдээллийг Нийслэлийн төрийн санд хүргүүлэн ажилласан.	100
53	Орон нутгийн 2018 оны батлагдсан төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарийг төсөвт байгууллага, орлогын нэр төрөл, зардал бүрээр боловсруулж батлуулах, үр дүнгээр нь санхүүжүүлж, гүйцэтгэлд нь хяналт тавих	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Төсвийн орлогын мэргэжилтэн, Төсвийн салбарын мэргэжилтэн		2018 оны төлөвлөгөөгөөр орон нутгийн төсөвт 25 725 520,6 мян төгрөгийн орлого орохоос урьдчилсан гүйцэтгэлээр 30 115 837,7 мянган төгрөг орж, 117,1 хувиар биелэгдэж байна. 0 сая төгрөгийг 100% бүрэн төвлөрүүллээ. Орон нутгийн төсвийн орлогын 2019 оны төслийг боловсруулахдаа хууль эрх зүйн орчны хүрээнд эдийн засгийн нөхцөл байдал, гадаад дотоод орчны нөлөөлөл зэргийг тооцон тайлан мэдээ, албан ёсны мэдээлэлд тулгуурлан орлогын нэр төрөл бүрээр тооцооллыг хийж, 2019 оны төсвийн орлогын төслийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2018 оны орлогын төлөвлөгөөнөөс 7,0 тэрбум төгрөг буюу 27,4 хувиар өсгөж нийт орон нутгийн төсвийн орлогыг 32 тэрбум 784,9 сая төгрөг байхаар төсөвлөн	100

			өргөн барьяа.	
5 4	Тусгай зориулалтын санхүүжилтээр санхүүжих боловсрол, эрүүл мэнд, соёл, спортын байгууллагуудын 2018 оны батлагдсан төсвийн зарлагын сар, улирлын хуваарийг төсөвт байгууллага, зардал бүрээр боловсруулж батлуулах	Төсвийн салбарын мэргэжилтэн	2018 онд Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд болох төрийн өмчийн 19 сургууль, хувийн хэвшлийн 16 сургууль, төрийн өмчийн 29 цэцэрлэг, хувийн хэвшлийн 82 цэцэрлэг, 16 өрхийн эрүүл мэндийн төв, соёл спортын байгууллагуудын сарын хуваарийг төсвийн жилийн батлагдсан дүнгээр сар бүр тооцоолол хийн, ачаалал үүсгэхгүй байхаар төлөвлөн санхүүжилтийг олгосон.	100
5 5	Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хуулийн хугацаанд төрийн санд харьяалагдах байгууллагуудаас хянаж хүлээн авах, нэгтгэн зохих дээд байгууллагад сар бүр мэдээлэх, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллах	Төсвийн орлогын мэргэжилтэн, Тайлан, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн	Төрийн болон хувийн хэвшлийн нийт 178 байгууллагын Төсвийн гүйцэтгэлийн 1,2,3,4,5,6,7,8,9,10,11 сарын мэдээг хуулийн хугацаанд хүлээн авч хянан баталгаажуулж, орлогыг зардал бүрээр бичилт хийж, өр авлагын мэдээг сар бүр хүлээн авч програмд шивж оруулан дүүргийн төсөвт байгууллагуудын нэгдсэн орлого, зарлага, өр авлагын мэдээг бэлтгэн, Нийслэлийн санхүү төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргүүлсэн.	100
5 6	Дүүргийн Засаг даргаас боловсролын байгууллагуудын төсвийн шууд захирагч нартай байгуулах 2018 оны үр дүнгийн гэрээний төслийг боловсруулж, гэрээ байгуулах, дүгнэх ажлын хэсэгт орж ажиллах	Төсвийн зарлагын мэргэжилтэн	Боловсролын хэлтэс болон ЭЗТХ, Нийгмийн бодлогын хэлтэс хамтран дүүргийн боловсролын төсвийн байгууллагуудын төсвийн шууд захирагч нартай 2018 оны 3 дугаар сард үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж гэрээ дүгнэх	100
5 7	Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу зарлага, санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олгох	Ерөнхий нябо	“Засгийн газрын санхүүгийн удирдлага мэдээллийн систем”-ийн сүлжээ буюу “FreeBalance” программын журнал ваучераар оны эхний 11 сард орон нутгийн 10 байгууллага, 6 хөтөлбөр, Засаг даргын нөөц, ОНХО, ОНХСан, 4 ОНӨААТҮГазарт нийт 15.273.406,8 мянган төгрөг, тусгай шилжүүлгийн 150 байгууллагад 37,348,641,2 мянган төгрөг нийт 52,622,048,0 мянган төгрөгийн зарлага, санхүүжилт олгож нийслэлд 7,190,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэв.	100

58	Дүүргийн төсөвт байгууллагуудын улирал, жилийн санхүүгийн тайлан тэнцлийг хянаж хүлээн авах, нэгтгэл судалгаа хийх, дүүргийн нэгдсэн хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд нийтэд мэдээлэх	Ерөнхий нябо, Тайлан, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн 2017 оны жилийн эцэс, 2018 оны 1,2,3 дугаар улирлын нийт 180 байгууллагын санхүүгийн тайлан тэнцлийг шалган хүлээн авч нэгтгэсэн. 2017 оны нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлтийг шилэн дансны хуулийн дагуу shilendans.gov.mn сайт, дүүргийн сайтанд хуулийн хугацаанд байршуулж нийтэд мэдээлсэн. 2017 оны жилийн эцэс болон 2018 оны 1,2,3 дугаар улирлын тайланг санхүүгийн тайлангийн нэгтгэл, дотоод хяналт хийх зориулалт бүхий “Талст” программыг ашиглан Засгийн Газрын санхүүгийн нэгтгэлийн Э-ТАЙЛАН-ийн системд дүүргийн ОНБ-8, ОНӨААТҮГ-4, сан-3, ТШБ-165 байгууллагын тайланг нэгтгэлээ.	
59	Төрийн сангийн гүйлгээг хуулийн хугацаанд зохих журмын дагуу хийж гүйцэтгэх, төсвийн санхүүжилтийг зохицуулахдаа Сангийн Сайдын 73 дугаар тушаалыг мөрдөж ажиллах	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Төсвийн салбар хариуцсан мэргэжилтэн		Сангийн Сайдын 2014 оны 01 дүгээр сарын 10 –ны өдрийн 05 тоот тушаал, 2018 оны 06-р сарын 08-ны өдрийн 134 дугаар тушаал, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам, холбогдох бусад хууль эрхзүйг өдөр тутам мөрдөн ажиллаж байна.	100
60	Төсвийн байгууллагын өглөг, авлагыг барагдуулах, нэмж өр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх	Төсвийн зарлагын мэргэжилтэн, Төсвийн салбар хариуцсан мэргэжилтэн		Төсөвт байгууллагуудын өр авлагын асуудалд байнгын хяналттай ажиллаж, Сангийн яам болон Нийслэлийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу ажиллаж байна.	100
1 1 6	Ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийтийн зориулалттай орон сууцны мэдээллийн санг баяжуулан шинэчилнэ.	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	Дүүргийн 9 хорооны 84 орон сууцны насжилт, хүчин чадал, барилгын үндсэн хийц бүтэц, газар хөдлөлтөд тэсвэртэй эсэх суурь судалгаа хийж мэдээлэлийн санг баяжуулсан.	97
1 1 7	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн суурь судалгаанд суурилан хэсэгчилсэн инженерийн дэд бүтэцтэй болох иргэдийн санал санаачлагыг дэмжин	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	Дэд бүтцийн төвд хамрагдах өрхийн төлөөлөлд 2 удаагийн сургалт зохион байгуулж 10 иргэдийн бүлэг байгуулан тэдгээрийн санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилснаар дүүргийн 9 дүгээр хорооны 9,10 дугаар хэсэг,	97

	ажиллана.			Центр, Буянт-Ухаа 23-р гудамжны нийт 15 га газарт 200 нэгж талбарыг хамарсан Дэд бүтцийн төв байгуулах ажлын байршил Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын 9-ний өдрийн 118 дугаар тогтоолоор батлагдсан.	
1 1 8	Гэр хорооллын дэд бүтцийн суурь судалгааны мэдээллийн сан байгуулна.	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газартай хамтран суурь судалгаа хийж, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагад тулгуурлан Туул тосгон, Биокомбинат, Морингийн даваа, Нисэх, Яармагийн гэр хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийг боловсруулсан.	96
1 1 9	5 дугаар хорооны АШ-ний 80 айлын нийтийн байрны дахин төлөвлөлтийн ажлыг эрчимжүүлэн орон сууцыг ашиглалтанд оруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		“Нью Биг Фиш Констракшн” ХХК нь төслийн гүйцэтгэгчээр шалгарч, АШ-ний 80 айлын 10 дугаар байрыг буулган 2 давхар 40 айлын орон сууцыг барьж дуусган Улсын комисс ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	100
1 2 0	Бие даасан болон төвлөрсөн инженерийн шугам сүлжээнд холбогдох хүсэлтэй иргэдийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж гарсан санал хүсэлтийг дээд шатны байгууллагад уламжилна.	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу дүүргийн 5 дугаар хорооны Яармагийн 1, 2, 3 дугаар гудамж, Цогийн 1 дүгээр гудамжны нийт 229 нэгж талбарын иргэдээс дахин төлөвлөлтөд хамрагдах эсэх талаар судалгаа авах ажлыг зохион байгуулсан. Дахин төлөвлөлтөд хамрагдах боломжтой нийт 229 нэгж талбар судалгаанд хамрагдахаас 184 нэгж талбар буюу 80.3%-с судалгаа аваад байна. Судалгаа өгөхөөс татгалзсан - 5, Түрээслэгч - 9, эзэнгүй буюу хороонд бүртгэлгүй 25 нэгж талбар байна. Судалгаанд хамрагдсан нийт 184 нэгж талбарын 86 нэгж талбар буюу 46.8% нь газараа дахин төлөвлөн барилгажуулах хүсэлтэй байгаа бол 98 нэгж талбар буюу 53.2% газраа шинэчлэн зохион байгуулж дэд бүтэцтэй болох хүсэлт ирүүлсэнийг Нийслэлийн гэр хороолол дэд бүтцийн газар хүргүүлсэн.	97
1 2 1	Гэр хорооллын оршин суугчдын дунд дахин төлөвлөлтийн ажлын чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулна.	Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн 9 дүгээр хороонд “Дэд бүтцийн төвд” хамрагдах 200 өрхийн төлөөлөлд 2 удаагийн сургалт зохион байгуулж, хэсэгчилсэн болон бие даасан инженерийн хангамж буюу “Дэд бүтцийн төв”-н танилцуулах материал тараасан. 10 иргэдийн бүлэг байгуулан тэдгээрийн санал хүсэлтийг холбогдох байгууллагад уламжилсан.	96
1 2 2	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, зургийн даалгавар боловсруулах, хэрэгжүүлэх	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил,		Дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжин 2018 онд хэрэгжих 37 төсөл арга хэмжээнээс 17 төсөл арга хэмжээнд зургийн даалгавар боловсруулж холбогдох байгууллагаар батлуулсан 14 төсөл,	100

		хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		арга хэмжээнд ажлын даалгавар боловсруулж, төсөв зохиолгон “МССС корпорейшн” ХХК-аар магадлал хийлгэсэн. 6 төсөл арга хэмжээнд бараа материалын тодорхойлолт боловсруулан дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлсэн. Мөн Нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл арга хэмжээний зургийн даалгавар холбогдох баримт бичгийг боловсруулан ажиллав.	
1 2 3	Шинээр хэрэгжүүлэх боломжтой төсөл арга хэмжээний судалгаа гаргаж, зургийн даалгавар боловсруулах	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх боломжтой зураг төсөвтэй ажлын жагсаалтыг авч мэдээллийн сан үүсгэсэн. 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 төсөл арга хэмжээний зургийн даалгаврыг боловсруулан батлуулж дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн.	100
1 2 4	Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, боловсруулах ажлын явцад хяналт тавих	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн төсөв, Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжих 17 төсөл арга хэмжээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд ажиллаж. Зураг төсөв гүйцэтгэсэн “Оргилт од” ХХК, “Эм Эс Эл” ХХК-ийн гүйцэтгэлд захиалагчийн хяналт тавьж ажилласан.	100
1 2 5	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний явцад хяналт тавих	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн Засаг даргын 2018 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн А/238 дугаар захирамжаар байгуулагдсан техник хяналтын ажлын хэсэг дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих нийт 19 төсөл арга хэмжээнд хяналт тавихаас 11 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавин хүлээн авсан бөгөөд гэрээ байгуулсан 3 төсөл арга хэмжээнд явцын хяналт тавьж байна. Дүүргийн Засаг даргын 2018 оны 07 сарын 27-ны өдрийн А/238 дугаар захирамжаар байгуулагдсан техник хяналтын ажлын хэсэг дүүргийн Орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй нийт 21 төсөл арга хэмжээнээс 15 төсөл, арга хэмжээний ажлын явцад хяналт тавин хүлээн авч ажилласан. 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцад тавьж байна.	100
1 2 6	Нисэх, Яармагийн бүсэд амралт, чөлөөт цаг, аялал жуулчлалын зурвас байгуулах суурь судалгаа хийж хөрөнгийн эх үүсвэрийг судалж холбогдох дээд шатны байгууллагад уламжилна.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Нисэх, Яармагийн бүсэд иргэдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх газрын байршлыг судлан ИНЕГ-тай зөвшилцөж Буянт-Ухаа Олон Улсын Нисэх онгоцны буудлын хойд талын төв зам дагуу 4 улирлын цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар төлөвлөн холбогдох хууль журмын дагуу гүйцэтгэгч сонгон шалгаруулах түлхүүр гардуулах нөхцөлтэй тендер 2018 оны 10 сарын 26-нд зарлаж, 11 сарын 26-нд нээлт хийсэн. /2018 оны 09 сарын 04-ний өдөр сонгон шалгаруулалт зарлаж 10 сарын 04-нд нээлт	90

				хийсэн боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул дахин зарласан/	
1 2 7	Шинээр байгуулах шаардлагатай хүүхдийн тоглоомын талбай болон газар доорх авто зогсоолын байршлын судалгааг гаргана.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний талаар дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороод болон иргэдээс санал авч мэдээллийн нэгдсэн сан байгуулсан. Дүүрэгт газар доорх авто машины зогсоол байгуулах 2, хүүхдийн тоглоомын талбай байгуулах 12 байршлын санал ирүүлсэн.	90
1 2 8	Туул голын дагуу амралт, үйлчилгээний газар байгуулах боломжтой газрын байршлыг тогтоож улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын санхүүгийн дэмжлэгээр бүтээн байгуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн Төсөл, хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Туул, дунд голын дагуу байршлын судалгаа хийж Зайсангийн гүүрнээс Яармагийн гүүр хүртэл туул голын үерийн далангийн дагуу нийт 2000м газарт унадаг дугуй, гүйлтийн зам бүхий эко зурвас байгуулах ажлын зургийн даалгаврыг боловсруулж зураг төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарлаад байна. Туул гол дагуу ундны усны хамгаалалтын бүс дэх амралт, үйлчилгээний төвүүдийг нүүлгэх газар чөлөөлөх тухай Байгаль орчин, Ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга Хот байгуулалтын сайдын 2015 оны А/230/127 дугаар тушаалаар 100 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудад газар чөлөөлөх тухай албан шаардлага хүргүүлсэн. Шинэ байршлын бүсүүдийн судалгааг гарган ажиллаж байна.	90
1 2 9	Нийслэлийн ерөнхий төлөвлөгөө, дүүргийн онцлогтой уялдуулан хот төлөвлөлтийн нэгдсэн загвар, шийдэл гаргах судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийж, хороодын байрны гадна фасад болон дотор тохижилтыг нэг хэв маягийн өнгө төрхтэй болгоно.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн хот төлөвлөлтийн нэгдсэн загвар, шийдэл гаргах судалгааны ажлын хүрээнд Эко Хан-Уул нэгдсэн мэдээллийн сан, хэрэгжүүлэх шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний мэдээллийн сан зэргийг байгуулсан. Мөн хороодын гадна фасад болон дотор тохижилтын үйлчилгээний стандартад нийцсэн жишиг зураг боловсруулж, зураг төсвийн дагуу дүүргийн ЗДТГ-ын 25.0 сая төгрөгийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд засварын ажил хийгдсэн.	90
1 3 0	75 дугаар сургуулийг буулгаж барилгажуулах, БУЦС, 52, 114 дүгээр сургуулиудын өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		75-р сургуулийн хуучин барилга буулгах ажил дуусч шинээр барилгажуулах ажил 30 хувьтай хэрэгжиж байна. БУЦС-ийн барилгын 2 давхрын цутгалтын ажил 60 хувьтай хэрэгжиж байна. 52-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгч түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр шалгарч гэрээ байгуулагдсан бөгөөд зураг төсөв 70 хувьтай хийгдэж байна. 114-р сургуулийн өргөтгөлийн барилгын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил 2 удаа зохион байгуулагдан Сангийн яаманд тендерийн материал хянагдаж байна.	100
1 3 1	3-р хороо 46 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн		46 дугаар цэцэрлэгийн барилгын ажлыг Улсын комиссын 2018 оны 01-р сарын 11-ний өдрийн 2018/20 дугаар шийдвэрээр хүлээн авч ашиглалтад оруулсан. Тус цэцэрлэгт 10 бүлгийн	100

		Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		320 хүүхэд хүмүүжиж байна.	
1 3 2	4-р ясли, 28 дугаар цэцэрлэгийн барилгыг буулгаж дахин барилгажуулах, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт шинэ цэцэрлэг барих ажил, 53, 49, 73 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын ажлыг улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		28 дугаар цэцэрлэгийн барилгын 2 давхрын цутгалтын ажил хийгдэж дууссан бөгөөд ажлын явц 50 хувь, 53 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын төмөр бетон каркас хийгдэж дууссан ажлын явц 40 хувь, 73-р цэцэрлэгийн зоорийн давхрын шал цутгаж, Зоорийн давхрын рамны арматурчлалын ажил хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 40 хувь, 14 дүгээр хороонд шинээр баригдаж буй 240 ортой цэцэрлэгийн барилгын төмөр бетон каркас хийгдэж дууссан, ажлын явц 40 хувьтай, 49 дүгээр цэцэрлэгийн өргөтгөлийн барилга барих ажлын гүйцэтгэгч шалгарч барилгын хашаа барих ажил хийгдэж байна. 4 дүгээр яслийн барилгыг буулгаж дахин барилгажуулах ажил гэрээ байгуулах шатанд байна.	100
1 3 3	8 дугаар хорооны нутаг дэвсгэрт хүүхэд залуучуудад зориулсан хөлбөмбөгийн талбай шинээр байгуулах ажлыг эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Улсын төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгөөр 8 дугаар хорооны 118 дугаар сургуулийн хашаанд хөл бөмбөгийн талбай байгуулах ажлыг "Гарден стити" ХХК гүйцэтгэж ашилалтад оруулсан.	100
1 3 4	Шинээр усан спорт сургалтын төв байгуулах шаардлагатай газрын байршлыг тогтоож санхүүгийн эх үүсвэрийг улс, нийслэлийн төсөвт суулгуулах ажлыг зохион байгуулна.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн 3-р хороо, Спорт хорооны зүүн талд байрлах талбайд Усан спорт сургалтын төв байгуулахаар төлөвлөсөн. Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраас архитектур төлөвлөлтийн даалгавар хүлээгдэж байна.	90
1 3 5	Дүүрэгт хүүхдийн зуслан байгуулах ажлын судалгаа, байршлыг тогтоож зураг, төсөв хийлгэх ажлыг эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт хүүхдийн зуслан байгуулахаар төлөвлөж зургийн даалгавар боловсруулсан. Зураг төсвийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендер зарлагдах шатанд байна.	90
1 3 6	Дүүргийн төрийн болон үйлчилгээний байгууллагуудад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй үйлчилгээ, жишиг болохуйц	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил,		"Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил"-ийн аяны хүрээнд Манай хороо-Миний гудамж" аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байгаа	90

	тохижилттой болгох ажлыг шат дараатайгаар зохион байгуулна.	хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		эсэхэд үнэлгээ хийх ажлыг “Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран зохион байгуулсан. Үнэлгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн оролцоотойгоор, мөн сайн дурынхны тусламжтай хийж гүйцэтгэснээрээ онцлог ажил болсон. Мөн дүүргийн иргэдэд үйлчлэх төв байр болон хороодын нэг цэгийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлүүлэх стандартад нийцүүлэн тохижуулах ажил хийгдсэн. Дүүргийн эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, хүлээн авах цонх, зам, үзлэгийн кабинетыг тохижуулж, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангасан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 60 дугаар сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургуульд сурах нөхцөлийг бүрдүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн.	
1 3 7	Ахмадын сувилал байгуулах ажлын судалгааг хийж, зураг төсөв хийлгэх ажлыг эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн Газрын албатай хамтран байршлын судалгааг хийж 8-р хороо жаргалантын аманд 1,0 га сонгон дүүргийн Засаг даргын захирамж гарсан. Зураг төсвийг боловсруулах гүйцэтгэгчийг шалгаруулах зөвлөхийн үнэлгээний хороо байгуулагдан 03 дугаар сарын 26-ны өдөр тендер зарлагдсан.	100
1 3 8	Гэр хороололд гэмт хэрэг хамгийн ихээр гардаг цэгүүдэд хэсэгчилсэн камер суурилуулах ажлыг Цагдаагийн 2 дугаар хэлтэстэй хамтран үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 4, 5, 6, 7, 8-р хороонд хийх камержуулалтын ажил бүрэн хэрэгжиж дууссан бөгөөд нийт 116 ширхэг камер нэмэгдсэн байна. Нийслэл дүүргийн ОНХС-ын хөрөнгөөр 2, 8, 9, 10, 16-р хороодод хийгдэх камержуулалтын ажлын суурилуулах цэгийг Цагдаагийн 1,2-р хэлтэстэй хамтран гаргасан. 8, 9-р хорооны камержуулалтын ажил бүрэн дуусч 2, 10, 16 дугаар хорооны камержуулалтын ажлын явц 90 хувьтай байна.	100
1 3 9	Камержуулах шаардлагатай сургууль, цэцэрлэг, хүүхдийн тоглоомын талбайн судалгаанд үндэслэн камержуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжийн дэмжлэгтэйгээр хэсэгчилэн эхлүүлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		БУЦС, 114, 118 дугаар сургуулийн гадна болон дотор талт нийт 15, “Шинэ Хан-Уул”, “Янгирт” цэцэрлэгт хүрээлэнд 21, 3-р хорооны 32-р байрны гаднах тоглоомын талбайд 8, нийт 44 камер шинээр суурилуулсан.	100
1 4 0	Төвийн болон Яармаг, Нисэхийн чиглэлд хороо харгалзахгүй үйлчилгээ авах 1 цэгийн үйлчилгээний төвийг ажиллуулж эхэлнэ.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт		Байршлын судалгааг Нисэх Яармагийн бүсэд хийсэн бөгөөд газар байхгүйн улмаас нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх байрыг тухайн байршлын ойр орчимд түрээслэн хэрэгжүүлэх судалгаа дахин хийж байна.	70

		хариуцсан мэргэжилтэн			
1 4 1	Гэмт хэрэг ихээр бүртгэгддэг хороодын нутаг дэвсгэрт байршлын судалгаанд үндэслэж цагдаагийн кабон барих ажлыг дээд шатны байгууллагуудад уламжилна.	Барилга, зураг төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Орон нутгийн хөгжил, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн		Дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт цагдаагийн хэсэг шинээр байгуулахаар төлөвлөж зураг төсвийг хийлгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зарласан.	70
ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТЭС					
1 4 2	Сар шинийн баярыг угтан дүүргийн ахмад настнуудад хүндэтгэл үзүүлнэ.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	42,800,000	Сар шинийн баярыг угтан ахмад настнуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг 2018 оны 02 дугаар сарын 10-20-ны өдрүүдэд хороо тус бүр хуваарийн дагуу зохион байгуулж, дүүргийн Засаг даргын гарын бэлгийг зорилтот өрхийн 2000, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс харьяалалгүй 1600 ахмад настнуудад тус тус гарын бэлэг өгч хүндэтгэл үзүүлсэн.	100
1 4 3	Нийслэлийн "Цасны баяр"-ын үйл ажиллагаанд зохион байгуулалтыг ханган оролцоно.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	6,027,5	2018 оны 02 дугаар сарын 24-ний өдөр Хандгайтын "Янзага" зусланд зохион байгуулагдсан "Мөнгөн Улаанбаатар-2018" цасны баяр, биеийн тамир, спортын өвлийн үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, алба, хороодын нийт 800 гаруй ажилтан, албан хаагчид оролцлоо. Хэлтэс, албадын ажилтан, албан хаагчдын дунд спортын 3 төрлөөр тэмцээн уралдаан зохион байгуулсан. Хан-Уул дүүрэг байгууллагын нийлбэр дүнгээр нийслэлийн хэмжээнд "Тэргүүн байр"-нд шалгарч, Өргөмжлөл, Цом, мөнгөн шагналаар шагнагдсан.	100
1 4 4	"Улаанбаатарын өвлийн наадам-2018" арга хэмжээнд зохион байгуулалтыг ханган оролцоно.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1,998,0	2018 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд "Улаанбаатар өвлийн наадам-2018" Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулагдлаа. Наадамд дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, хороодын 461 иргэд оролцож Нийслэлийн 9 дүүргийн 152 хороодоос Хан-Уул дүүргийн 7 дугаар хороо "Үндэсний хувцастай иргэдийн парад"-д Тэргүүн байр эзэлсэн.	100
1 4 5	Бид "Эко дүүргийн хүүхдүүд" хүүхдийн чуулган зохион байгуулна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	1 804 500	2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "Эко дүүргийн хүүхдүүд бидэнд үе тэнгийн гадуурхал үгүй" сэдэвт хүүхдийн чуулганыг зохион байгуулав. Чуулганы үеэр үе тэнгийн гадуурхлыг бууруулахад сургууль, багш, эцэг, эх, хүүхдийн оролцооны талаар 4 бүлэгт хуваагдан хэлэлцүүлсэн бөгөөд зөвлөмж боловсруулан гаргаж дүүргийн удирдлагуудад хүргүүллээ. Тус чуулган нь англи хэл дээр зохион байгуулагдаж хувийн сургуулиудыг оролцуулснаараа онцлог боллоо. Чуулганд 20	100

				сургуулийн 80 сурагч оролцов.	
1 4 6	Дүүргийн залуучуудыг хөгжүүлэх идэвхжүүлэх зорилгоор "Эко дүүргийн залуучууд" чуулган зохион байгуулна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	6 150 600	Нийгмийн хөгжилд залуучуудын оролцоог идэвхжүүлэх, хөдөлмөрийн зах зээлд байр суурь эзлэхэд дэмжлэг үзүүлэх, хувь хүний манлайллыг өсгөх зорилгоор "ЗАЛУУСЫН ОРОЛЦОО-ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД" чуулганыг зохион байгууллаа. Чуулганд 16 хорооны 350 гаруй залуучууд оролцож шилдэг лекторуудын илтгэлийг сонсон, Залуучуудын оролцооны шилдэг бүлгүүдийн нийгмийн ажлын талаар хийж буй туршлагаудаа хуваалцлаа. Тус чуулганы үеэр томоохон аж ахуйн нэгж байгууллагуудын нээлттэй ажлын байртай танилцав. Уг чуулга уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 16 хорооны 786 залуучуудад "Хан-Уул Эко дүүргийн хөгжилд-хороодын залуусын оролцоо" сэдэвт сургалтууд явагдаж тэднийг уриалснаар Залуучуудын сайн дурын бүлгэмүүд байгуулагдан хороо, дүүрэгтээ өөрсдийн хувь нэмэрийг оруулах ажлуудыг хийж эхэлсэн. Залуучуудын бүлгэмийн санаачилсан ажлыг дэмжиж төслүүдийг шалгаруулан Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагын Хан-Уул дүүргийн орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс "Шувуун фабрик-Залуусын нэгдэл", "Өлзийт –Эко 25", "Яармагийн залуус" бүлгүүдэд тус бүр 3000 ам.долларын дэмжлэгийг олголоо.	100
1 4 7	"Цахлай" төслийн хэрэгжилтийг танилцуулах өдөрлөг зохион байгуулна.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	9 754 000	Хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах хүрээнд Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газраас "Цахлай" төслийг хэрэгжүүлэн 9-12 дугаар ангийн 1000 гаруй хүүхдийн цахим хэрэглээнд мэргэжлийн байгууллагатай хамтран, мэдээллийн технологийг ашиглан тандалт судалгааг хийлээ. Цахлай төслийг хэрэгжүүлснээр эцэг эх, багш, сургууль хоорондын уялдаа холбоо сайжирч, хүүхдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоход дэвшилтэт технологийг ашиглах, хүүхэд хамгааллын ажлыг сайжруулах ач холбогдолтой болов.	100
1 4 8	"Халдварт өвчин, эх хүүхдийн эндэгдэл, гэрийн төрөлтийг бууруулах чиглэлээр сургалт, зөвлөгөөн зохион байгуулна.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	4,993,5	Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, идэвхжил, дэгдэлтийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эмч, ажилчид, төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 400 эмч нарт "ХӨЦМ-ийн маягтаар 0-5 хүртэлх насны хүүхдийг үнэлж ангилах", "Давтан үзлэгийн хоног", "Хэзээ яаралтай эргэн ирэх", "Өвчтэй хүүхдийн хооллолт" зэрэг сургалтуудыг 8 удаа зохион байгуулсан. "Томуугаас хэрхэн сэргийлэх", "Зөв ханиаж, найтаах соёл" зэрэг сэдвүүдээр 5759 иргэд, эцэг,	100

				эхчүүдэд сургалт зохион байгуулсан. Дүүргийн Нисэх, Яармагийн бүсийн Ерөнхий боловсролын сургуулиудын 1-3 дугаар ангийн 3329 сурагчдыг агаар цэвэршүүлэх шүүлтүүртэй амны хаалтаар хангах ажлыг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.	
1 4 9	Хүн амын дунд халдварт бус өвчний эрсдэл болон хүндрэлээс сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулна. /ӨЭМТ-үүдэд аян өрнүүлж, дүгнэж урамшуулах/	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	5,500,000	Халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, өвчний эрт үеийн илрүүлгийн үзлэгийн хувийг нэмэгдүүлэх, хороод, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор дүүргийн 16 хороо, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд “Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийг сайжруулахад хороодын оролцоо” 4 сарын аяныг зарлаж 11 дүгээр сард дүгнэн эхний 3 байранд шалгарсан хороо болон өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 22 албан хаагчдыг гадаад улсад аялах эрхээр шагнасан. Эхний 11сарын байдлаар артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг-81.8%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг- 68.1%, хөхний хорт хавдрын илрүүлэг-41%, умайн хүзүүний хорт хавдрын илрүүлгийн хувь 31%-д хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрт илрүүлгийн дундаж хувь 8,7-аар өссөн байна. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 12 төрлийн сэдвээр сургалт сурталчилгааг 61 удаа хийж, 29387 иргэдийг хамруулж гарын авлага материал 11500 ш тараасан.	100
1 5 0	Дүүргийн ЕБС, цэцэрлэгүүдийн эмч, эцэг эхчүүд, сурагчдын дунд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг үе шаттай явуулах, хяналт тавих, тараах материал болон зурагт хуудас тараах, эрүүл мэндийн үзлэгт хамруулж эрүүлжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1000000	Нийслэлийн эрүүл мэндийн газар, Гүүд нейборс ОУБ хамтран дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш, сургалтын менежер, эмч нийт 450 албан хаагчдад 2018 оны 4 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд “Амны хөндийн эрүүл ахуй”-н чиглэлээр сургалт зохион байгуулсан. Амны хөндийн эрүүл мэндийн сэдэвт 2 төрлийн санамжийг шинээр боловсруулан гаргаж, 450 ширхгийг сургууль, цэцэрлэгээр тараасан. Зориудын урьдчилан сэргийлэх үзлэгээр 29, 46, 71, 73, 230, 218-р цэцэрлэг 7, 52, 15, 75, 32, 130-р сургуулийн нийт 4311 хүүхдийг хамруулсан. Шүд цоорох өвчний нийт тархалт 0-10 насанд 78.2%, эрчим 5 байна. 5-6 насанд шүд цоорлын тархалт 86,4%, эрчим 6, 12 насанд тархалт 63%, эрчим 2,3 байлаа. Энэ нь урд онтой харьцуулбал 0-18 насанд тархалт 0,5 % - р, 5-6 насанд тархалт 3,4%, 12 насанд тархалт 4%-р тус тус ихэссэн байна. 2018 оны эхний 11 сарын байдлаар нийт 4351 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж, анхдагчаар 2690 хүүхэд үйлчлүүлснээс 1449 буюу 54% -ийг	100

				эрүүлжүүлсэн байна.	
1 5 1	Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам" зохион байгуулна.	Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн	6 500 000	2018 оны 04 дүгээр сарын 03-06-ны өдрүүдэд дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хүүхдийн урлагийн Их наадам"-ыг зохион байгууллаа. Уг наадам нь Хүүхэд өсвөр үеийнхэнд Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, өвлүүлэх, сурталчлах, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх зорилготойгоор 3 насны ангиллаар цэцэрлэгийн 4, сургуулийн 8 төрлөөр зохион байгуулагдсан. Урлагийн их наадамд дүүргийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 40 цэцэрлэг, 18 сургуулийн 1771 хүүхэд багачууд оролцож авьяас билгээ сорилоо.	100
1 5 2	"Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлнэ.	Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн	1 998 300	2018 оны 1 сарын 11, 02 сарын 02-ны өдрүүдэд зохион байгуулсан Карл Попперын мэтгэлцээний сургагч багш, мэтгэлцэгч, шүүгч бэлтгэх сургалтад нийт 50 багш, 42 сурагчыг хамруулсан. Мэтгэлцээний клубүүдийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, ерөнхий боловсролын 16 сургуулийн 12 баг өрсөлдөж мэтгэлцээний аваргыг шалгаруулсан.	100
1 5 3	"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Дэд хөтөлбөр" боловсруулж, ХАБЭА-н салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	2 937 000	Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, хөдөлгөөнд соёлтой оролцох дадлага эзэмшүүлэх зорилгоор Цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд зохион байгуулагддаг "Замын хөдөлгөөний Цагаан толгой-2018" тэмцээнийг 2018.04.27- оос 30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тэмцээний 5 төрөлд нийт 27 цэцэрлэгийн 324 хүүхэд, 27 багш, 27 эцэг эх оролцож өрсөлдөн, тэмцээнд оролцсон хүүхэд бүрт дүүргийн Засаг даргын гарын бэлгийг гардуулан өгсөн.	100
1 5 4	Орон гэргүй, тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх "Гэртээ харих зам" хөтөлбөрийн хүрээнд тус дүүргийн нутаг дэвсгэрт орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдарч буй иргэд рүү чиглэсэн үйл ажиллагааг холбогдох хэлтсүүдтэй хамтран зохион байгуулна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	3 273 600	Хан-Уул дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эмэгтэй төлөөлөгчдийн санаачлагаар дүүргийн Засаг даргын Тамгын газраас "Ээж бол ертөнц" хүндэтгэлийн нэгдсэн арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Монголын Хүүхдийн ордонд зохион байгууллаа. Хүндэтгэлийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн 444 ээж уригдаж Монгол Улсын ерөнхийлөгчийн зарлигаар олгодог "Эхийн алдар 1" одонгоор 21, "Эхийн алдар 2" одонгоор 423 ээжийг шагнаж Хан-Уул дүүргийн удирдлагууд хүндэтгэл үзүүллээ.	100
1 5	Дүүргийн хэмжээнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт,	1,397,880	1. Хан-Уул дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн салбар зөвлөлөөс барилгын ажил эрхлэхэд хөдөлмөрийн	100

5	шаардлагатай ахмадын тоог гаргаж үе шаттайгаар эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулах ажлыг Эрүүл мэндийн төв, ӨЭМТ-үүдтэй хамтран зохион байгуулна.	индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн		<p>аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах, сайн туршлагыг барилгын талбайд үзүүлэн таниулах, харилцан туршлага солилцох зорилгоор “Номин констракшн деволопмент” группийн “Гарден Сити” барилга угсралтын талбайд үзүүлэх сургалтыг 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр нийслэлийн хэмжээнд анх удаа зохион байгууллаа. Сургалтад нийслэл Улаанбаатар хотын 6 дүүрэгт барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 260 байгууллагын 450 гаруй ажил олгогч, Барилгын инженер, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтнууд хамрагдлаа.</p> <p>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 1/2629 дугаартай “Улсын үзлэгийг зохион байгуулах тухай” албан тоотын дагуу Хан-Уул дүүрэгт хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг хөнгөн үйлдвэрийн салбарт зохион байгуулах тухай” удирдамжийн хүрээнд үзлэг шалгалтыг гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/309 тоот захирамжаар байгуулж, Хан-Уул дүүрэгт хөнгөн үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 61, хүнсний үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа 19, нийт 80 аж ахуйн нэгж байгууллага хамрагдлаа. Үүнд: Ноос ноолуурын 10, арьс шир боловсруулах 14, оёмол бүтээгдэхүүний 4, модон модон эдлэлийн 4, хэвлэлийн 6, цаас, сав, баглаа боодлын 5, барилгын материалын 17, гурилан бүтээгдэхүүний 3, исгэлтийн 9, органик хүнсний 3, эм, эмнэлгийн хэрэгслийн 4 үйлдвэр тус тус хамрагдаж, удирдамжинд заасан хүснэгт, асуумжийн дагуу үзлэгийг хийсэн. Нийт 80 байгууллагын 928 ажлын байранд ажиллаж буй 5117 ажилтан, 2836 тоног төхөөрөмжид үзлэг хийгдсэн.</p>	
1 5 6	Иргэд, хүүхэд залуучуудын дунд "Хотын соёл-Хоггүй дүүрэг" уриатайгаар олон нийтийн аян өрнүүлнэ.	Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн	2,973,000	<p>Аяны хүрээнд дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. АБНТБТ-тэй хамтран иргэдийн дунд сургалт зохион байгуулах, “Хаявал хог-Бүтээвэл баялаг” үйл ажиллагаа, 2. “Эко” телевизтэй хамтран иргэд, хүүхэд залуучуудад хотын соёлыг сурталчлах, экологийн боловсрол олгох, байгаль орчинг хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх чиглэлээр 5 төрлийн сурталчилгааг хийж, Эко телевиз, Гэгээнтэн кино театрын кино 	100

				дэлгэцээр нийтэд сурталчлах ажлыг хийсэн. Үүнд нийт 6000 иргэдийг хамруулсан.	
1 5 7	Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Цомын аварга" шалгаруулах тэмцээн, дүүргийн аж ахуй нэгжүүдийн дунд спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулна.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	0	Биеийн тамир, спортыг бүх нийтийн хөдөлгөөн болгох ажилтан албан хаагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, албадын ажилтан, албан хаагчдын дунд дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт цомын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 05 дугаар сарын 12-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Спортын 5 төрөлт /Боулинг, дартс, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг/-өөр нийт 24 хэлтэс, албадын нийт 800 гаруй албан хаагч /давхардсан тоогоор/ хамрагдсан. Байгууллагын нэгдсэн дүнгээр 1-р байрт Цагдаагийн нэгдүгээр хэлтэс, 2-р байрт Цагдаагийн хоёрдугаар хэлтэс, 3-р байрт Татварын хэлтэс тус тус шалгарсан.	100
1 5 8	"Дээлтэй Монгол-2018" арга хэмжээнд зохион байгуулалтыг ханган оролцоно.	Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1 412 350	2018 оны 07 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан "Дээлтэй монгол-2018" наадмын баярын жагсаалд төр захиргааны байгууллага, 16 хороодын иргэдийг хамарсан 240 иргэн оролцсон. Наадмын үеэр Монгол үндэсний тоглоом наадгайн өргөөг байгуулан 22 нэр төрлийн 300 гаруй тоглоомыг байрлуулж тоглох арга аргачлалыг англи хэл дээр орчуулан иргэд, жуулчдад танилцуулж ажилласан.	100
1 5 9	Олон Улсын ахмадын баярыг угтан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	0	2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар Олон улсын ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай асуудлыг хэлэлцэн "16 хороодод ахмадын баярыг зохион байгуулах тухай" төслийг баталсан. Тус төслийн дагуу хороо тус бүр өөрийн нутаг дэсвгэрт ахмадуудад хүндэтгэл үзүүлж, тэмцээн уралдаан, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулсан.	90
1 6 0	Монголын болон Олон Улсын багш нарын баярыг угтан дүүргийн тэргүүний сургууль, цэцэрлэгийг шалгаруулж, урамшуулна.	Боловсрол, соёл урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн	10,400,500	Дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/364 дүгээр захирамжаар батлагдсан "Дүүргийн оны тэргүүний сургууль, цэцэрлэг, багш, ажилтныг шалгаруулах журам"-ын дагуу 2018 оны 11 дүгээр сарын 30-нд шалгаруулалтыг хийж нийт төрийн болон төрийн бус өмчийн 2 сургууль, 2 цэцэрлэг, 24 багш ажилтны шалгаруулан шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулав.	100
1 6 1	Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спорт хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, дэмжлэг үзүүлнэ.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1050000	Хан-Уул дүүргийн болон Засаг даргын Тамгын газрын Биеийн тамир, спорт хамтлагийг шинээр байгуулан Засаг даргын Тамгын газрын болон дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын дунд спортын тэмцээн, "Улаанбаатар марафон-2018" олон	100

				Улсын гүйлтийн тэмцээнийг зохион байгуулан ажилласан. Биеийн тамир, спортын хамтлагтай хамтран зохион байгуулсан тэмцээнд нийт 6000 гаруй иргэд, ажилтан, албан хаагчид хамрагдсан.	
1 6 2	"Иргэдийн спортын VII Их наадам"-ыг зохион байгуулна.	Эрүүл мэнд, биеийн тамир, спорт, индексийн асуудал хариуцсан мэргэжилтэн	8,000,000	Нийслэлийн Иргэдийн спортын VII их наадмын 2 дахь шат буюу дүүргийн Иргэдийн спортын их наадам 05 сарын 15-аас 10 сарын 26-ны өдрүүдэд спортын 8 төрлөөр зохион байгуулагдаж 14 хорооны 966 тамирчин оролцсон. Дүүргийн спортын наадамд 1-р байрт 2 хороо, 2-р байрт 16 хороо, 3-р байрт 10 хороо шалгарсан бөгөөд түрүүлсэн хороодын баг тамирчид нийслэлийн аварга шалгаруулах шигшээ тэмцээнд оролцон алтан медаль-1, мөнгөн медаль-3, хүрэл медаль-1 хүртэж, нэгдсэн дүнгээр 4 байрт шалгарсан. Нийслэлийн шилдэг хороогоор 2 дугаар хорооны баг шалгарсан.	100
1 6 3	Дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэний зөвлөл"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, ХБИ-ийн эрхийг хамгаалах ОУ-ын өдрийг угтан зөвлөгөөн зохион байгуулна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	5000,000	<p>1. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2018 оныг "Иргэдийн оролцоотой-Амьдрах орчныг сайжруулах жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны А/44 дүгээр тушаалаар "Манай хороо-Миний гудамж" аяныг зарласан. Энэхүү аяны хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байгаа эсэхэд үнэлгээ хийх ажлыг "Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо"-той хамтран зохион байгууллаа. Үнэлгээг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өөрсдийн оролцоотойгоор, мөн сайн дурынхны тусламжтай хийж гүйцэтгэснээрээ онцлог ажил боллоо.</p> <p>2. "Монголын Рояль Академи"-тай хамтран 2018 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр "Эрүүл, аз жаргалтай ирээдүй" сайн үйлсийн аяныг зохион байгууллаа. Үйл ажиллагаанд тус дүүрэгт оршин сууж буй байнгын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй 0-4 насны хүүхдүүд, тэдний эцэг эхчүүд нийт 100 гаруй хүн оролцсон. Үйл ажиллагаанд оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэдний эцэг эхчүүдэд "Анунгоо" фармын мэргэжлийн эмч нар эрүүл мэндийн болон эмийн зохистой хэрэглээний талаар мэдээлэл зөвлөгөө өгч, нэг сарын витаминь хэрэглээ, ивээн тэтгэгчдийн гарын бэлэг гардууллаа.</p> <p>3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эхчүүдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, нийгмийн харилцаанд татан оролцуулах зорилгоор Хан-Уул дүүргийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эхийн өдөрлөгийг зохион байгууллаа. Эцэг эхчүүдэд сэтгэл судлаач Наранбаатар "Хувь</p>	100

			<p>хүний үнэ цэнэ” сэдвээр илтгэл тавьж сэтгэл зүйн зөвлөгөө өглөө. Эцэг эхчүүд Өдөрлөгт оролцсноор нэг өдрийг баяр баясгалантай өнгөрүүлж өөрт хэрэгцээтэй мэдээллийг авсан нь тэдэнд хүүхдээ хайрлан асрах итгэл үнэмшлийг өглөө. Өдөрлөгт 250 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг, эхийн хамтаар оролцсон бөгөөд хүүхэд бүрт гарын бэлэг өглөө.</p> <p>4. Олон Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аян зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын А/366 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар аян тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөний дагуу Хан-Уул дүүргийн нэрэмжит шилжин явах цомын аврага шагаруулах суугаа воллейболын тэмцээн, дүүргийн Албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран хороодын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 3 бүсэд хуваарилан Декупаж урлал, Саван, бөмбөлөг хийх сургалтанд хамруулсан. Хан-Уул дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос нийслэлийн 6 дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан урлагийн тоглолт зохион байгуулах ажилд ХУД-ийн ЗДТГ дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Мөн Эрүүл мэндийн төвтэй хамтран ХБИ-ийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, эрүүл зөв хоололтын талаар сургалт , зөвлөгөө өгч эрүүл мэнд, сургалт арга зүй, урлаг спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.</p>	
1 6 4	"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр"- ийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн	<p>○ МУЗГ-ын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг дүүргийн Засаг даргын 2018.03.06-ны өдрийн А/76 дугаар захирамжаар шинэчлэн байгууллаа. Хан-Уул дүүргээс 2018 онд нийт 884 өрхийг сонгож, өрх бүрээр дэлгэрэнгүй судалгааг гаргасан. Зорилтот 884 өрхийг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадад хуваарилж, хуваарийг 2018.06.13-ны өдрийн 04/1220 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Тус дүүргийн 4 дүгээр хорооны зорилтот 2 өрхөд ТББ-аас гэр олгуулсан. /4 дүгээр хорооны иргэн Б.Энхболд, Г.Солонго/ - Хэрэгцээгээр нь ангилсан судалгаанд үндэслэн төрийн үйлчилгээг 874 иргэнд хүргэсэн. - Сайн үйлсийн аян-102 иргэн - Олон улсын болон төрийн бус байгууллагын тусламж-69 өрх - Хөдөлмөр эрхлэлт-Байнгын ажлын байр-24, Түр ажлын 	100

			<p>байр-53</p> <p>Иргэдийн зан үйл, дадал хэвшлийг өөрчлөх сургалт, сурталчилгаа- 559 иргэн тус тус хамрагдаад байна.</p> <p>16 хорооноос гаргасан судалгааг үндэслэн тус хөтөлбөрт хамрагдсан орон гэргүй 3 ахмад настнуудад, өөрийн гэсэн гэр оронгүй, олон хүүхэдтэй 1 өрхөд хөтөлбөрийн санхүүжилтээр тус тус нийт 4 гэр олгосон.</p> <p>Дэлхийн зөн Монгол ОУБ-тай хамтын ажиллагааны хүрээнд өрхийн амьжиргаа сайжруулах, тэдний нөөц боломжийг нээн илрүүлж, чадавхид тулгуурлан хөгжүүлэх зорилгоор 36 сар буюу 3 жилийн Төгсөлтийн Аргачлал хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг.Өнгөрсөн хугацаанд тус дүүргээс 350 өрхийг сонгож 2 удаагийн төгсөлт хийснээс 152 өрх амжилттай төгсөж 2019 оны 1 дүгээр сард 121 өрх төгсөхөд бэлэн болоод байна. Ирэх жилийн санхүүгийн жилд Төгсөлтийн аргачлалд хамрагдах 70 өрхийг сонгох уулзалтыг 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулж уг аргачлалд хамрагдах өрхийг шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд, хугацааг тодорхойлсон.</p> <p>7 дугаар хорооны зорилтот бүлгийн 2 өрхийн 2 хүүхдийг 28-р цэцэрлэгт, 1 хүүхдийг клиник сувилалд хамруулсан бөгөөд 1 өрхөд Сүүн сэтгэлийн дэм ТББ-тай хамтран 4 ханатай хуучин гэр өгсөн. Зорилтот бүлгийн 10 иргэнийг бүлэг болгон зохион байгуулж “Манай хороо-Миний гудамж” аяны хүрээнд зохион байгуулсан хашаа будах ажилд хамруулсан.</p> <p>Улсын бүртгэлийн хэлтсээс хороодоос гаргасан судалгаан дээр үндэслэн тулгалт хийж иргэний үнэмлэхний 25, 45 насны хугацаа дууссан боловч хугацаандаа авч чадаагүй, 16 нас хүрээд иргэний үнэмлэхээ авч чадаагүй нас хэтэрсэн, мөн төсрний гэрчилгээ гээгдүүлсэн зэрэг зөрчлүүдтэй иргэдийн судалгааг тусгайлан гаргасан.</p> <p>Дүүргийн Эрүүл мэндийн төвөөс идэвхтэй эрт илрүүлэгээр зорилтот бүлгийн 8000 хүнийг урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулахаас 9695 хүнийг хамруулсан. 2018 онд нөхөн үржихүй насны буюу зорилтот бүлгийн 9084 эмэгтэйчүүдийг умайн хүзүүний хавдрын урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгт хамруулахаас эхний 10 сарын байдлаар 2605 иргэнийг үзлэгт хамруулаад байна . Үзлэг шинжилгээгээр үрэвсэл эмгэгтэй илэрсэн 48 хүнийг хяналтандаа авч эмчилгээнд хамруулснаас 25 нь бүрэн эмчлэгдэж эдгэрсэн ба 23 нь эмчилгээ үргэлжлэн хийгдэж байна.</p>	
1	Соёлын өвийн талаар сургалт зохион	Боловсрол, соёл	Дурсгалт газруудаар аялах, судалгаат хичээлийг 2018 оны 5	100

6 5	байгуулах, "Улаанбаатар хот" гэрэл зурагт явуулын үзэсгэлэн, Музейн үзвэр үзүүлэх, Хотын аялал зохион байгуулна.	урлагийн асуудал хариуцсан мэргэжилтэн		дугаар сарын 30 –ны өдөр зохион байгуулж Хан-Уул дүүргийн 32 дугаар сургуулийн 2 багш, 8 дугаар ангийн 25 сурагчийг хамруулан дүүргийн нутаг дэвсгэр дэх хөшөө, дурсгалт газруудаар аялал хийх 1 дүгээр маршрутын дагуу судалгаат хичээлийг зохион байгууллаа. Хичээлд Хан-Уул дүүргийн ууган иргэд зочин багшаар оролцож дүүргийн үүсэл хөгжил, бүтээн байгуулалтын талаар сурагчдад ярьж өглөө. Дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай Засаг даргын байгуулах үр дүнгийн гэрээнд хотын үүсэл хөгжил, түүх соёлын дурсгалт газруудаар аялах, музей үзүүлэх ажлыг тусган хэрэгжүүлж нийт 2018 онд нийт 18 сургуулийн 2452 сурагч, цэцэрлэгийн 863 хүүхдэд музей үзүүлж сургалтыг зохион байгуулсан байна.	
